

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай
хуулийн хэрэгжилт”-д хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: ДОА-2023/30-9-ШТА-НА

Чойбалсан хот
2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Аудитор Г.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёог.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
БҮЛЭГ А. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ НЬ ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ, ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬТАЙ БҮРЭН УЯЛДАХГҮЙ, ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	7
А.1. Орон нутгийн хөгжлийн бодлогын дунд, богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар 2021-2022 онд дэвшүүлсэн арга хэмжээ 83-96 хувьтай хэрэгжсэн байна.....	7
А.1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь Газрын төлбөрийн тухай хууль болон Төсвийн тухай хуультай уялдахгүй байна.....	7
А.1.2. Аймгийн хэмжээнд дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг баталж, 2021-2022 онуудад тусгасан төсөл, арга хэмжээ 83-96 хувьтай хэрэгжсэн байна.....	7
А.1.3. Аймгийн ой, ус, агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаа 2021-2022 онд дуусаж, 2017 оноос хойш газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй явж байна.....	10
А.2. БОАЖС, аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагч, сумдын Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж дүгнэсэн байна.....	11
А.2.1. БОАЖС аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан 2021, 2022 оны гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.....	11
А.2.2. Аймгийн Засаг дарга БОАЖГ-ын дарга, сумдын Засаг даргатай байгуулсан 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох арга хэмжээг тусгаж, дүгнэсэн байна.....	11
БҮЛЭГ Б. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХЭРЭГЖИХГҮЙ БАЙНА.....	12
Б1. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.....	12
Б1.1. Аймгийн ИТХ нь Дорнод аймгийн хэмжээнд 2021-2023 онуудад агнах ан амьтны тоо хэмжээг тогтоож батлаагүй, БОАЖЯ-наас 2023 онд барих загасны төрөл, дээд хэмжээг хугацаа хоцроож баталсан байна.....	12
Б1.2. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.....	13
Б1.3. Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон байна.....	13
Б1.4. БНАТ-ын төлбөрийг өмнөх жилийн дундаж хэмжээг баримтлан төлөвлөж, үндэслэлгүй ноогдуулж, төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй байна.....	14
Б2. Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт хуулийн дагуу хэрэгжихгүй байна.....	15
Б.2.1. БОХНС арга хэмжээнд усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд заасан хувь хэмжээний дагуу төлөвлөж, батлахгүй байна.....	15
Б.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд 2021 онд 4 төсөл арга хэмжээ буюу 16%, 2022 онд 5 төсөл арга хэмжээ буюу 17.8% нь төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.....	17
БҮЛЭГ В. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙН, НӨХЦӨЛ БАЙДАЛД ТОХИРОХ АРГА ХЭМЖЭЭ АВААГҮЙ БАЙНА.....	18
В.1. Хууль, журмын хэрэгжилт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт муу байгаа нь төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.....	18
В.1.1. Хууль, журмын хэрэгжилт, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн бүрдүүлэлт муу байна.....	18
В.1.2. Аймаг, сумдын Засаг дарга, БОАЖГ хууль, журмын хэрэгжилтийг хангахад үр дүнтэй хамтарч ажиллаагүй байна.....	19
В.2. Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үр дүнг үнэлээгүй байна.....	20
В.2.1. БОАЖЯ-аас байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийгдээгүй байна.....	20
В.2.2. Аймгийн ИТХ нь хяналт тавих эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	20
Холбогдох байгууллагын санал, саналд өгсөн тайлбар:.....	21
ДҮГНЭЛТ:	22
САНАЛ:	23
ЗӨВЛӨМЖ:	24
ТУШААЛ:	25

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын стандарт
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОХНСАХ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ДОА	Дорнод аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НА	Нийцлийн аудит
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
УИХ	Улсын Их Хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс
ШТА	Шууд тайлагналын аудит
MNS	Mongolian national standard

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөгжлийн бодлогын баримт бичигт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр тусгагдсан ТАХ-ний тоо, хэрэгжилт 2021-2022 он	8
Хүснэгт 2	Газрын тос, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэсэн талаарх судалгаа 2014-2022 он	10
Хүснэгт 3	Байгалийн нөөц ашиглалтын төрөл дээд хязгаарыг тогтоосон байдал	12
Хүснэгт 4	Мод модон материалын гарал үүслийн гэрчилгээ олголтын байдал	14
Хүснэгт 5	БНАТ-ын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл 2021-2022 он	14
Хүснэгт 6	БНАТ-ын орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь, хэмжээ	15
Хүснэгт 7	Усны төлбөрийн орлого, зарцуулахаар төлөвлөсөн хэмжээ	16
Хүснэгт 8	БОХНСАХ-ний хэрэгжилтийн судалгаа	16

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх****Аудитын зорилт****Аудитын
хамарсан хүрээ****Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт****Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дүгээр тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийлээ.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх;

Аудитад аймаг, сумын ИТХ, ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Буйр нуур – Мэнэнгийн талын сав газрын захиргаа, Онон – Улз голын сав газрын захиргаа, Баян-Уул сумын Сум дундын ойн ангийн 2021-2023 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 онд баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилт, дэд зорилт, асуудлын шинжилгээнд хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, тодруулга хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Я.Зориг, аудитор С.Энхбаатар, Г.Ганбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын хөтөлбөрийг 2023 оны 5 дугаар сарын 10-ны дотор батлуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2023 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж хэлэлцүүлэн, тайлан, холбогдох судалгааг 6 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газар, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

БҮЛЭГ А. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь Газрын төлбөрийн тухай, Төсвийн тухай хуультай бүрэн уялдахгүй, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

А.1. Орон нутгийн хөгжлийн бодлогын дунд, богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар 2021-2022 онд дэвшүүлсэн арга хэмжээ 83-96 хувьтай хэрэгжсэн байна.

А.1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь Газрын төлбөрийн тухай хууль болон Төсвийн тухай хуультай уялдахгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 3.2 дахь хэсэгт “Газар болон түүний хэвлийн нөөц ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна.” гэж заасны дагуу тус харилцаа нь Газрын төлбөрийн тухай хуулиар зохицуулагдаж байна.

1. БНАТ-ийн тухай хуулийн 18.1 дэх хэсэгт “Газрын нөөцийн төлбөрийн орлого”-оос 15 хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна гэсэн нь Газрын төлбөрийн тухай хууль дахь нэр томьёотой нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл “Газрын нөөцийн төлбөр” гэсэн ойлголт нь Газрын төлбөрийн тухай хуульд тухайн нэршил байхгүй, газрын нөөц гэдэгт юуг хамааруулахыг зааж өгөөгүй, “Газрын төлбөр” гэсэн ойлголтоор зохицуулагдаж байна.

2. Мөн Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.1¹-д газрын төлбөрийг сумын төсөвт /2020 онд орсон өөрчлөлтөөр/, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1²-д /2022 онд орсон өөрчлөлтөөр/ газрын төлбөрийн орлогыг аймаг, сум, нийслэл, дүүргийн төсөвт оруулахаар заасан нь тус хуулиуд хоорондоо нийцэхгүй байна. Тухайлбал Төсвийн тухай хуульд зааснаар газрын төлбөрийн орлого 2021 оноос сумын төсөвт орж эхэлсэн байхад Газрын төлбөрийн тухай хуулиар 2022 оноос газрын төлбөрийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэхийг давхар заалт болгон оруулж, газрын төлбөр гэдэгт юу хамааруулахыг зааж өгөөгүй байна. Газрын төлбөрийн тухай хуульд орсон өөрчлөлтөөс шалтгаалж аймагт газрын ямар төрлийн төлбөр орох талаар Татварын хэлтэс, ГХБХБГ, аймгийн ЗДТГ-ын СТСХ нь нэгдсэн ойлголтгүй байна. Иймд эдгээр нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5³ дахь заалттай уялдахгүй байна.

Энэ нь хуулийг батлахдаа нэр томьёо, утга агуулгын хувьд зөрүүтэй байдлаар баталсантай холбоотой байна. Цаашид БНАТ-ийн тухай хуулийн 18.1 болон газрын төлбөрийн тухай хуулийн 10.1, Төсвийн тухай хуулийн 23.8.1 дэх заалтуудыг уялдуулан өөрчлөлт оруулах шаардлага үүссэн байна.

А.1.2. Аймгийн хэмжээнд дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг баталж, 2021-2022 онуудад тусгасан төсөл, арга хэмжээ 83.6-96.5 хувьтай хэрэгжсэн байна.

Монгол Улсын хөгжлийн бодлогын урт хугацааны “Алсын хараа-2050”, дунд хугацааны Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн бодлогын баримт бичгийг УИХ-аас 2020 онд тус тус баталсан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан улсын хэмжээнд батлагдан хэрэгжиж байсан “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”, “Ус үндэсний хөтөлбөр”, “Ногоон хөгжлийн бодлого”, “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” зэрэг баримт бичгүүдийг УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоолоор тус тус хүчингүй болсонд тооцсон байна. Үүнтэй

¹ 23.8.Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ: 23.8.14.газрын төлбөр;

² 10.1. Газрын төлбөрийн орлогыг аймаг, сум, нийслэл, дүүргийн төсөвт оруулна.

³ 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;

холбогдуулан аймгийн түвшинд байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр дэд хөтөлбөр батлагдаагүй байна.

Аймгийн түвшинд “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021, 2022, 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг баталжээ. Аймгийн хөгжлийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр туссан төсөл, арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №1. “Хөгжлийн бодлогын баримт бичигт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр тусгагдсан ТАХ-ний тоо, хэрэгжилт 2021-2022 он”

№	Бодлогын баримт бичиг	Дэвшүүлсэн зорилт	2021 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний		2022 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
Дунд хугацааны бодлогын баримт бичиг						
1	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	3	19	83.6	20	91
2	Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	6	38	89	70	96.5
Богино хугацааны бодлогын баримт бичиг						
1	Дорнод аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	5	26	93.8	-	-
2	Дорнод аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	4	-	-	26	87.9

Эх сурвалж: Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн аудиторын судалгаа 2021-2022 он

Аудитын явцад БОАЖГ-аас нэгдсэн судалгаагаар ирүүлсэн дүн, аудиторын тулган баталгаажуулалт хийсний дүнд дунд хугацааны бодлогын баримт бичигт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой тусгасан зорилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2021 онд 83.6-89 хувь, 2022 онд 91-96.5 хувийн хэрэгжилттэй байна. Харин богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зорилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2021 онд 93.8 хувь, 2022 онд 87.9 хувийн хэрэгжилттэй байна. Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс жил бүр бодлогын баримт бичгүүдэд нийт зорилтын хэмжээнд буюу ерөнхий байдлаар үнэлгээ өгсөн байна.

Бодлогын баримт бичгүүд дэх төсөл, арга хэмжээнүүд бүрэн хэрэгжээгүй нь байгалийн нөөц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр ус, ой, ан амьтантай холбоотой төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ИТХ, Засаг дарга, БОАЖГ-аас хяналт тавихгүй байгаатай холбоотой байна.

А.1.3. Аймгийн ой, ус, агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаа 2021-2022 онд дуусаж, 2017 оноос хойш газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй явж байна.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан ус, рашаан, байгалийн ургамал, амьтан, ойн тухай хуулиудаар менежментийн төлөвлөгөөг баталж, нөөцийн судалгааг хийх талаар тус тус заасан байна.

Аймгийн хэмжээнд Буйр нуур - Мэнэнгийн талын сав газрын захиргаа, Онон – Улз голын сав газрын захиргаа, Хэрлэн голын сав газрын захиргаа үйл ажиллагаа явуулж байгаагаас 2 сав газрын 3 менежментийн төлөвлөгөө, ой, агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаа дууссан байна.

Байгалийн ургамал: Байгалийн ургамлын тухай хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7^{1.14} дэх хэсэгт зааснаар ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жилээр буюу 2018-

⁴ 1.Үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна.

2023 оныг хүртэл мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/43 дугаар тушаалаар ховор ургамлын жагсаалтад орсон дэрэвгэр жиргэрүү ургамлыг 2018.03.01-2023.01.01-ний өдрийг хүртэл түүж бэлтгэхийг хориглосонтой холбогдуулан зөвшөөрөл олгогдоогүй байна.

Ой: Ойн тухай хуулийн 17.2.10⁵, 17.3⁶, 18.2.8⁷, 21.1⁸ дэх хэсгүүдэд аймгийн Засаг дарга, Байгаль орчин аялал жуулчлалын газар, сумын Засаг дарга нар нь ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх талаар заасан байна.

Баян-Уул сумын ой зохион байгуулалтын ажлын хүчинтэй хугацаа 2012-2022 он хүртэл үргэлжилж, аймгийн ойн менежментийн төлөвлөгөө 2011-2015 онд хэрэгжиж дууссан байна. Тус суман дахь Сум дундын ойн ангийн менежментийн төлөвлөгөөг 3 жилийн хугацаатай буюу 2020-2022 он хүртэл хэрэгжүүлэхээр аймгийн Засаг дарга баталж, хэрэгжүүлсэн боловч хэрэгжилтийг үнэлээгүй байна. Сум дундын ойн анги болон аймгийн БОАЖГ-аас ойн тооллого, ой зохион байгуулалтыг хийлгэх талаар 2021 оноос эхлэн БОАЖЯ-нд хүргүүлсэн боловч улсын төсөвт тусгагдаагүй шалтгаанаар ой зохион байгуулалтын ажил хийгдээгүй, ойн менежментийн төлөвлөгөө одоог хүртэл батлагдаагүй байна.

Ус, рашаан: Усны тухай хуулийн 4.7 дахь хэсэгт БОАЖЯ нь усны менежментийн төлөвлөгөөг баталж, 20.4.3⁹ дахь хэсэгт сав газрын зөвлөл нь сав газрын захиргааны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авахаар заасан байна.

Аймгийн хэмжээнд Буйр нуур - Мэнэнгийн талын сав газрын захиргаа, Онон – Улз голын сав газрын захиргаа, Хэрлэн голын сав газрын захиргаа үйл ажиллагаа явуулж байгаагаас 2 сав газрын 3 усны менежментийн төлөвлөгөөний хугацаа дууссан байдалтай байна. Тухайлбал:

1. Буйр нуурын усны менежментийн төлөвлөгөө 2014-2021 он хүртэл хэрэгжиж, хугацаа нь дууссан байна. Мэнэнгийн усны менежментийн төлөвлөгөө 2019-2030 он хүртэл 2 үе шаттай хэрэгжихээр батлагдсан байна.
2. Онон-Улз голын сав газрын усны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа дууссан байна. Тухайлбал Онон голын усны менежментийн төлөвлөгөө 2011-2021 он хүртэл, Улз голын усны менежментийн төлөвлөгөө 2014-2021 он хүртэл хэрэгжсэн байна.
3. Хэрлэн голын сав газар нь Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж, Дорнод аймагт асуудал хариуцсан 1 мэргэжилтэнтэй байна. Тус газрын усны менежментийн төлөвлөгөөг 2017-2030 хүртэл буюу 2 үе шаттай хэрэгжүүлэхээр баталсан байна.

Усны 2 сав газрын менежментийн төлөвлөгөө 2021 онд дуусаж, одоог хүртэл шинэчлэн батлагдаагүй байгаа нь БОАЖЯ болон сав газрууд нь чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

⁵ 17.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.2.10.ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

⁶ 17.3.Аймаг, нийслэлийн Байгаль орчны газар нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 17.3.9.ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

⁷ 18.2. Сум, дүүргийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.2.8.ойн нөөцийн бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, сумын ойн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх;

⁸ 21.1.Ойн нөхөрлөл нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байна.

⁹ 20.4.3.сав газрын захиргааны усны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах шийдвэр гаргуулах, хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллагад санал хүргүүлэх;

Ан, амьтан: Амьтны тухай хуулийн 5.3.2¹⁰ дахь хэсэгт БОАЖЯ нь аймгийн болон ангийн аж ахуйн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг баталж, хяналт тавих талаар заасан байна.

БОАЖЯ-наас ан агнуурын менежментийн төлөвлөгөөг 2017-2021 он хүртэл баталж, хэрэгжүүлсэн боловч 2022 оноос хэрэгжих менежментийн төлөвлөгөө батлагдаагүй байна. Энэ нь БОАЖЯ-наас менежментийн төлөвлөгөөний төслийг хянаж байгаатай холбоотой байна. Менежментийн төлөвлөгөөний нарийвчилсан төлөвлөгөөг “Дорнод ан трейд” ХХК хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайлан болон шинэчилсэн менежментийн төлөвлөгөөний төслийг БОАЖЯ-нд хянуулж, батлуулахаар хүргүүлсэн байна.

БОАЖЯ-наас Буйр нуураас үйлдвэрлэлийн зориулалтаар олборлох загасны тоо хэмжээ, аймгийн хэмжээнд барих шонхор шувууны тоо хэмжээг тус тус тогтоож байгаатай холбогдуулан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Газар: Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2¹¹-т зааснаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2014 онд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг баталсан байна. Гэвч Геодези зураг зүйн газраас 2017 онд гаргасан дүгнэлтээр “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэт ерөнхий, хэрэгжилтийг тооцох боломжгүй байдлаар батлагдсан байна.” гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл аймгийн түвшинд 2017 оноос хойш газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй явж ирсэн байна.

Шинээр батлагдах аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 2021 оноос эхлэн “Гео ботаник” ХХК гүйцэтгэж, гэрээний дагуу хүлээлгэж өгөх хугацаа болоогүй байна.

Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг жил бүрийн ИТХ-ын тогтоолоор баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Дээрх ой, усны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ, аймгийн Засаг дарга, БОАЖГ, Усны сав газруудаас үнэлж, дүгнэн хэрэгжилтийг тооцоогүй байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.12¹² дахь хэсэгт байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих субъектийг зааж өгсөн байна.

Хүснэгт 2. “Газрын тос, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэсэн талаарх судалгаа 2014-2022 он”

		Аж ахуйн нэгжийн нэр	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Газрын тос	“Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн гэрээт 19 дүгээр талбай	80.0	37.0	80.0	74.4		82.2	45.7		95.1
2		“Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн гэрээт 21 дүгээр талбай	87.0	49.8	80.0	80.3	82.1	84.8	54.0		90.4

¹⁰ 5.3.Амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид “төрийн захиргааны төв байгууллага” гэх/ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.3.2. агнуурын нөөц бүхий аймаг болон ангийн аж ахуйн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

¹¹ 20.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын харилцааны талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 20.1.2.тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах;

¹² 9.12.Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.

3	Ашигт малтмал	“Найнг” ХХК	Төлөвлөгөөгүй							
4		“Дун уянга” ХХК	80.3	87.7	85.1		84.0	92.4	90.0	
5		“Дун эрдэнэ” ХХК	78.4							
6		“Эс Жи Майнинг Эрдэс” ХХК	84.3	80.9	87.5	80.06	83.6	92.9		89.0
7		“ТОУУ” ХХК	2012 оноос хойш төлөвлөгөөгүй ажиллаж байгаа							
8		“Буман-олз” ХХК	Төлөвлөгөөгүй							

Эх сурвалж: БОАЖГ-ын судалгаа 2023 он.

Судалгаанаас үзэхэд Дорнод аймагт газрын тос, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдээс байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан дээрх аж ахуйн нэгжүүд байна. Менежментийн төлөвлөгөөгүй ажиллаж байгаа нь тус ААНБ-уудын хариуцлагагүй байдал, аймаг, сумын байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, төрийн бус байгууллагууд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаагаар холбоотой байна.

А.2. БОАЖС, аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагч, сумдын Засаг дарга нарын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж дүгнэсэн байна.

А.2.1. БОАЖС аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан 2021, 2022 оны гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.

БОАЖС аймгийн Засаг даргатай байгуулсан 2021, 2022 оны хамтран ажиллах гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.

Аудитын явцад сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг дүгнэсэн тухай танилцуулгыг үзэхэд 21 аймгийн гэрээний үүргийн биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгсөн байна.

Мөн БОАЖС харьяа аймгийн Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаа, Онон-Улз голын сав газрын захиргааны даргын 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.

А.2.2. Аймгийн Засаг дарга БОАЖГ-ын дарга, сумдын Засаг даргатай байгуулсан 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох арга хэмжээг тусгаж, дүгнэсэн байна.

Аймгийн Засаг дарга БОАЖГ-ын даргатай байгуулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 26, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 32 байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох арга хэмжээг тусгаж, 80-85 хувьтай дүгнэсэн байна. Тухайлбал, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байна.

Мөн аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулсан 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох арга хэмжээг тусгаж дүгнэсэн байна.

БҮЛЭГ Б. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжихгүй байна.

Б.1. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.

Б.1.1. Аймгийн ИТХ нь Дорнод аймгийн хэмжээнд 2021-2023 онуудад агнах ан амьтны тоо хэмжээг тогтоож батлаагүй, БОАЖЯ-наас 2023 онд барих загасны төрөл, дээд хэмжээг хугацаа хоцроож баталсан байна.

Байгаль орчныг хамгаалах талаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүрэн эрхийг “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь хэсэгт “Нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тогтоох” гэж заасан байна.

Аймгийн ИТХ нь орон нутагт 2023 онд үйлдвэрийн зориулалтаар барих загас, 2021, 2022 онд ойгоос мод бэлтгэх дээд хязгаарыг БОАЖС-ын баталсан дээд хязгаарт багтааж төлөвлөсөн байна. Харин 2023 онд үйлдвэрийн зориулалтаар барих загасны хэмжээ, 2021-2023 онуудад орон нутагт тухайн жилд агнах ан амьтны тоо хэмжээг тус тус тогтоож батлаагүй байна.

Хүснэгт 3. “Байгалийн нөөц ашиглалтын төрөл дээд хязгаарыг тогтоосон байдал”

Он	Зориулалт	Төрөл зүйл	БОАЖС-ын тушаалаар		АИТХ-ын тогтоолоор	
			Шийдвэрийн огноо, дугаар	тоо хэмжээ	Шийдвэрийн огноо, дугаар	тоо хэмжээ
2021 он	Тусгай	Ан агнуур	2020.12.30 №А/701	49 ш		
	Ахуйн	Ан агнуур	2020.12.30 №А/701	1050 ш		
	Үйлдвэрийн	Ан агнуур	2020.11.27 №А/658	30 тн	2020.12.25 №01	25 тн
	Ойгоос бэлтгэх мод	Ой мод	2020.09.28 №А/599	4520 м³	2020.12.03 №05	4520 м³
2022 он	Ойгоос бэлтгэх мод	Ой мод	2021.08.10 №А/217	4440 м³	2021.12.03 №7/01	1840 м³
	Тусгай	Ан агнуур	2022.06.15 №А/208			
2023 он	Ахуйн	Ан агнуур	2023.01.10 №А/05	1032 ш		
	Ойгоос бэлтгэх мод	Ой мод	2022.08.29 №А/327	3600 м³	2022.12.01 №13/05	1657.5м³
	Үйлдвэрийн	Ан агнуур	2023.01.10 №А/05	30 тн		
	Нийт дүн					

Эх сурвалж: Аудиторын судалгаа

БОАЖС-ын ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар 2023 онд барих агнуурын загасны тоо хэмжээний дээд хязгаарыг 2022 онд батлаагүй, 2023 оны 01 сарын 11-нд баталж, үүний дагуу аймгийн ИТХ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалтын дагуу агнуурын загас болон ан амьтны нөөцийн дээд хэмжээг тогтоох эрх, үүргээ хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Б.1.2. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ төсвийн

жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана” гэж заасны дагуу Дорнод аймаг 2021 онд БНАТ-ийн орлогоос 1.3 тэрбум төгрөгийг, 2022 онд 1.4 тэрбум төгрөгийг байгаль орчныг нөхөн сэргээх төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмаар зохицуулдаг. Тус журмын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”, 2.3 дахь хэсэгт “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.2-т заасан саналыг хянан, ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг тогтоож, жил бүрийн 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ” гэж заасны дагуу аймгийн Засаг дарга ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа БОАЖЯ-нд хүргүүлэн ажиллаагүй байна.

Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг “БОХНС арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн программаар орлогын төлөвлөгөөг БНАТ-ийн маягтыг хүргүүлдэг. Аймгийн БОАЖГ-т тус программыг 2022 оны 4 дүгээр сард танилцуулсан бөгөөд журмын дагуу БНАТ-ын маягтаар орлогын төлөвлөгөөг хүргүүлж хэвшээгүй байна.

Б.1.3. Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон байна.

Дорнод аймгийн хэмжээнд Баян-Уул сум ойн нөөц ашиглах зөвшөөрөл, Халхгол суманд үйлдвэрлэлийн зориулалтаар барих агнуурын загасны зөвшөөрлийг тус тус олгодог. Баян-Уул сумын ИТХ-ын тогтоол, Халхгол сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор БОАЖС-ын тушаал, аймгийн ИТХ-ын тогтоолыг үндэслэн байгалийн баялгийн нөөц ашиглах аж ахуйн нэгжид олгох зөвшөөрлийн тоо хэмжээг баталсан байна.

Ой ашиглалтын чиглэлээр аймаг, сумын ИТХ, Засаг дарга дараах шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд:

- Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 сарын 05-ны өдрийн “2021 онд ойгоос бэлтгэх модны тоо хэмжээний дээд хязгаарыг батлах тухай” 05 тоот тогтоол
- Баян-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “2021 онд ойгоос бэлтгэх модны тоо хэмжээ дээд хязгаарыг батлах тухай” 12 тоот тогтоол
- Баян-Уул сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн “Ойгоос түлээний мод бэлтгүүлэх тухай” А/04 тоот захирамж
- Баян-Уул сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн “Ойгоос хэрэглээний мод бэлтгүүлэх тухай” А/26 тоот захирамж

Баян-Уул сумаас 2021 онд 215 ширхэг мод модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгож нийт 1609,8 м³ мод, модон материал, 2022 онд 124 ширхэг мод модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгож нийт 910,3 м³ мод, модон материал тус тус бэлтгэсэн байна.

Хүснэгт 4. “Мод модон материалын гарал үүслийн гэрчилгээ олголтын байдал”

№	Байгууллагын нэрс	Тээвэрлэсэн модны хэмжээ, м3 /2021 он/	Тээвэрлэсэн модны хэмжээ, м3 /2022 он/
1	“Бавж-барас”ХХК	358.3	98.5
2	“Нарс мод”ХХК	340.6	374.2
3	“Өвөр-Эрэн”ХХК	539.9	189.9
4	“Баянхангайн баялаг”ХХК	216.6	184.2
5	Нөхөрлөл	6.6	28.5
6	Иргэд	147.8	35
НИЙТ		1,609.8	910.3

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Үйлдвэрлэлийн зориулалтаар барих агнуурын загасны чиглэлээр аймаг, сумын ИТХ-аас дараах тогтоолыг баталсан байна. Үүнд:

- Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 сарын 25-ны өдрийн “2021 онд барих агнуурын загасны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоох тухай” 01 тоот тогтоол
- Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг тогтоох тухай” тогтоол

Буйр нуураас 2021 онд үйлдвэрлэлийн зориулалтаар барих агнуурын загасны эрхийг “Дорнын мөнгөн буйр” ХХК-д 7 тн, “Найман орд” ХХК-д 6 тн, “Азийн бүргэд” ХХК-д 6 тн, “Буйрын толио” ХХК-д 6 тн тус тус олгосон байна.

Б.1.4. БНАТ-ийг өмнөх жилийн дундаж хэмжээг баримтлан төлөвлөж, үндэслэлгүй ногдуулж, бүрэн төвлөрүүлээгүй байна.

Аймгийн Татварын хэлтэс нь БОАЖГ-аас ирүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төслийн саналыг үндэслэн төлөвлөсөн байна. Байгалийн нөөцийн орлогод 2021 онд 3.8 тэрбум төгрөгийг төлөвлөж, 3.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 94.7%-ийн, 2022 онд 3.9 тэрбум төгрөгийг төлөвлөж, 3.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 82%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 5. “БНАТ-ын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл 2021-2022 он”

№	Аймгийн төсөв/он/	Орлогын төрөл	ИТХ-ын тогтоол		Гүйцэтгэл /мянган.төг/	Зөрүү
			Шийдвэрийн огноо, дугаар	Батлагдсан дүн /мянган.төг/		
1	2021	БНАТ	2020.12.04 №05	3,830,000.0	3,663,923.4	166,076.6
	Нийт дүн			3,830,000.0	3,663,923.4	166,076.6
2	2022	БНАТ	2021.12.0 №7/09	3,949,513.0	3,255,033.1	694,479.9
	Нийт дүн			3,949,513.0	3,255,033.1	694,479.9

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Хүснэгтэд дурдсан БНАТ-ийн орлогын гүйцэтгэлтэй холбогдуулан үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 2021 онд 166.0 сая төгрөгөөр, 2022 онд 694.4 сая төгрөгөөр тасарсан нь “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Шинь шинь ХХК, “Стэпгоулд” ХХК зэрэг томоохон уул уурхай компаниуд цар тахлын улмаас тээвэрлэлтийн үйл ажиллагаагаа зогсоож, саарал ус хэрэглэх болсонтой холбоотой байна.

Газрын төлбөрийн орлогыг 2021 онд аймагт 0.5 тэрбум төгрөгөөр төлөвлөж 1.0 тэрбум төгрөг төвлөрүүлж, 2022 онд Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг сумын төсвийн орлогод төлөвлөж, аймгийн төсөвт өмнөх оны үлдэгдэл 1.6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

Газрын төлбөрийн 2023 оны 05 дугаар сарын байдлаарх 5.9 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэл нь 2023 оны ногдуулалтын 3.8 тэрбум төгрөг, өмнөх онуудын

үлдэгдэл 2.1 тэрбум төгрөгөөс бүрдэж байна. Иймд өмнөх онуудаас төлөгдөөгүй үлдсэн өр төлбөрийг барагдуулах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Татварын нэгдсэн систем дэх өмнөх оны ан амьтны нөөц ашигласны төлбөрийн үлдэгдэл 7.5 сая төгрөг, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн үлдэгдэл 30.0 сая төгрөг байгаа нь тайлагнал, бичилтийн алдаанаас шалтгаалан үүссэн үндэслэлгүй ногдуулалт байна. Өмнөх онуудад татварын системд ус, ан амьтны нөөцтэй холбоотой үүссэн өр төлбөрийн асуудалд залруулга хийх шаардлага үүссэн байна.

Б.2. Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт хуулийн дагуу хэрэгжихгүй байна

Б.2.1. БОХНС арга хэмжээнд усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд заасан хувь хэмжээний дагуу төлөвлөж, батлахгүй байна.

Тухайн төсвийн жилд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь хэмжээг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт дараах байдлаар заасан.

Хүснэгт 6. “БНАТ-ын орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хувь, хэмжээ”

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын хувиар/
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15 хувь
Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35 хувь
Газрын нөөцийн төлбөрийн орлого	15 хувь
Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
Ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь

Эх сурвалж: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль

Төсвийн тухай хууль болон Татварын ерөнхий хуульд эдгээр орлогоос ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын бүрэлдэхүүн болох үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогоос бусад орлогыг сумын төсөвт төвлөрүүлэхээр заасан байна.

Усны төлбөрийн 2021 оны 3.6 тэрбум төгрөгийн орлогоос 0.2 тэрбум төгрөг буюу 5.5%-ийг, 2022 онд 3.2 тэрбум төгрөгийн орлогоос 0.8 тэрбум төгрөг буюу 25% -ийг ус, рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төлөвлөж, 2021 онд 4.4%-ийг, 2022 онд 21.9%-ийг зарцуулсан байна. Үүнээс үзэхэд усны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн хувь хэмжээ нь хуульд зааснаас 10-30 хувиар бага байна.

Хүснэгт 7. “Усны төлбөрийн орлого, зарцуулахаар төлөвлөсөн хэмжээ”

он	Төлөвлөгөө			Зөрүү /сая.төг/
	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого /сая.төг/	Зарцуулахаар төлөвлөх доод хэмжээ/сая.төг/	Зарцуулахаар төлөвлөсөн хэмжээ/сая.төг/	
2021	3,663.9	1,282.3	208.0	1074.3
2022	3,255.0	1,139.2	797.4	345.2

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Энэ нь төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу үр дүнтэй байдлаар төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Сумдын Засаг дарга нь газар, ус, ой, ан амьтны нөөц ашигласны төлбөрөөс орж ирэх төлбөрийн орлогыг сумын төсөвт төвлөрүүлсэн боловч хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж, батлуулаагүй байна.

Б.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд 2021 онд 4 төсөл арга хэмжээ буюу 16%, 2022 онд 5 төсөл арга хэмжээ буюу 17.8% нь төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2021 онд БНАТ-ийн орлогоос 3.6 тэрбум төгрөг төвлөрүүлж, уг орлогын 29.7% болох 1.4 тэрбум төгрөгийг нийт 34 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар, 2022 онд 3.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, уг орлогын 35.5% болох 1.9 тэрбум төгрөгийг нийт 37 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар тус тус баталсан байна.

Хүснэгт 8. “БОХНСАХ-ний хэрэгжилтийн судалгаа”

№	Хэрэгжүүлэх, арга хэмжээ	2021 он				2022 он			
		Төлөвлөсөн	Хэрэгжсэн	Хэрэгжсэн мөнгөн дүн	Эзлэх хувь	Төлөвлөсөн	Хэрэгжсэн	Хэрэгжсэн мөнгөн дүн	Эзлэх хувь
1	Шилжих ажлын 2021 оны төсвийн үлдэгдлээс санхүүжих	8	7	278,684.90	28%	5	2	57,489.00	7%
2	Шилжих ажлын 2022 оны төсвөөс санхүүжих	26	18	487,741.30	72%	32	26	1,180,339.40	93%
2.1	Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах ажлын хүрээнд	7	4	131,434.70	16%	1	1	45,807.00	3.5%
2.2	Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах ажлын хүрээнд	5	4	160,596.60	16%	10	9	702,894.00	32.1%
2.3	Ойг хамгаалах, ойжуулах, ойн нөхөн сэргээлтийн арга хэмжээг эрчимжүүлэн ойн хомсдол доройтлыг бууруулж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах ажлын хүрээнд	11	8	112,204.30	32%	12	9	321,991.40	46.4%
2.4	Хог хаягдлын менежментийг сайжруулж хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд				4%	2	1	29,990.00	3.5%
2.5	Биологийн төрөл зүйл, ан амьтдыг хамгаалах ажлын хүрээнд	2	1	4,880.20	4%	2	2	27,854.00	7%
3	Нэмэлт тодотгол	1	1	78,625.50	/хог/	5	4	77,571.00	/ой/
	Нийт	34	25	766,426.20		37	28	1,237,828.40	

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг авч үзвэл 2021 онд 32%-ийг 2022 онд 46.4% хувийг ой хамгаалах, ойжуулах, ойн нөхөн сэргээлтийн арга хэмжээг эрчимжүүлэн ойн хомсдол доройтлыг бууруулж экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах ажилд зарцуулсан байна.

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын 3 дахь хэсэг, 2022 оны 02 дугаар тогтоолын 3.5, 3.6-д нийцэхгүй арга хэмжээнд зарцуулагдсан, ажлын даалгаврын

дагуу хийгдээгүй, ашиглалтгүй хөрөнгө бэлтгэсэн зэрэг нийт 607.9 сая төгрөгийн 9 арга хэмжээнд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

-2022 онд хэрэгжсэн Улз голын эргийн нөхөн сэргээх арга хэмжээ 20 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын даалгаварт /Чулуунхороот сумын нутагт иргэдийн ахуйн хэрэгцээндээ хайрга авч эвдрэлд оруулсан /0.5 га талбай бүхий 3 хэсэг газар/ нийт 1.5 га газарт техникийн нөхөн сэргээлт хийнэ гэж заасан байхад ажлын даалгаврын дагуу Улз голын зүүн эрэг дэх 0.5 га газар болон ажлын даалгаварт тусгаагдаагүй борооны усанд идэгдэж гэмтсэн хуссан замыг ковш машинаар шороо дүүргэн тэгшлэх ажил хийгдсэн байна.

-2022 онд хэрэгжсэн Мод үржүүлгийн газар байгуулах, дэмжлэг /Булган сум/ арга хэмжээ 20 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын даалгаварт 200м төмөр хашаа хийхээр төлөвлөсөн боловч 1х3м-ийн харьцаатай 65 ширхэг хашаа буюу нийт 195м хашаа хийж гүйцэтгэсэн байна.

-2022 онд хэрэгжсэн ус цэнгэгжүүлэх төхөөрөмж бүхий ундны усны худаг гаргах ажил 371.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээний хүрээнд Гурванзагал, Халх гол сумдад нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж ашиглалтгүй байна.

- 2021 онд хэрэгжсэн Хэрлэн голын эргийг талхагдлаас хамгаалах зорилгоор зам барих 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээ нь 160м урт цементэн бетон хучилттай авто зам, 300 м² урт явган хүний зам барих ажил хийгдсэн байна.

-2021 онд хэрэгжсэн Сум дундын ойн ангийн барилгын засвар, тохижилт /Баян-Уул сум/ 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээ нь тус ой ангийн байрыг засах, халаалтын яндан угсрах, халаалтын тогоо суурилуулах, паркетан шал хийх зэрэг тохижилтын ажил хийсэн байна.

-2022 онд хэрэгжсэн Иргэдийн экологийн боловсрол, хүмүүжил, нөлөөллийн 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээний хүрээнд 23.5 сая төгрөгийн хогийн сав худалдан авч аль нэг байгууллагын данс бүртгэлд тусгаж аваагүй, СӨХ-үүдэд хэрэглэж байна.

-2021 онд хэрэгжсэн Иргэдэд экологийн боловсрол, хүмүүжил, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, хогийг эх үүсвэрт нь ангилан ялгах 7.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээний хүрээнд Хэрлэн сумын 9 дүгээр багийн орон сууцны 5, 6-р байрны 160 өрхөд ангилан ялгах хогийн сав олгосон байна.

-2022 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийн зардалд 20.0 сая төгрөг төлөвлөн зардлын задаргаанд, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулах зардалд 3.0 сая төгрөг төлөвлөсөн боловч сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөн зохион байгуулаагүй, шатахуун томилолтын зардалд 5.0 сая төгрөг төлөвлөсөн боловч 7.3 сая төгрөг зарцуулж, шатахуун томилолтод 2.3 сая төгрөгөөр илүү зарцуулсан байна.

-2021 онд Чойбалсан хотын хогийн цэг дэх хог хаягдлыг дарж булах ажилд шаардагдах зөвлөн туслах ажил 2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй арга хэмжээний хүрээнд Б.Дэлгэрбаярт баталгаажаагүй гэрээгээр ажлын хөлс 700.0 мянган төгрөг, зөвлөн туслах үйлчилгээний ажилтны бензинд 672.0 мянган төгрөг, хоолны зардалд 628.0 мянган төгрөг, нийт 2.0 сая төгрөгийг зарцуулсан байна.



Хуссан замыг шороо дүүргэн тэгшлэх ажил хийгдсэн байна.



1х3м-ийн харьцаатай нийт 195м хашаа хийсэн байна.



Ус цэнгэгжүүлэх төхөөрөмж Халхгол, Гурванзагал суманд тоног төхөөрөмж ашиглалтгүй байна.



160м урт цемент бетон хучилттай авто зам,
300 м² урт явган хүний зам барих ажил



Баян-Уул сумын Сум дундын ойн ангийн барилгын засвар

БҮЛЭГ В. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ аваагүй байна.

В.1. Хууль, журмын хэрэгжилт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт муу байгаа нь төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.

В.1.1. Хууль, журмын хэрэгжилт, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн бүрдүүлэлт муу байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2-ийн 9-д байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах мэдээллийн технологийн иж бүрдлийг “байгаль орчны мэдээллийн сан” гэж заажээ.

Аудитаар 2021-2023 оныг хамруулан Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн тайлагнал, Байгаль орчны мэдээллийн сан /eic.mn/-гийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн бүрдүүлэлт, ил тод байдлыг хангасан эсэхийг үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Аймгийн Засаг дарга БНАТ-ийн орлогоос БОХНСАХ-ний зардлыг төлөвлөж байгаа ч ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан журмын хавсралт маягтын дагуу аймаг, сумын БНАТ-ийн орлогын гүйцэтгэлийн тайланг нэгтгэж тухайн шатны ИТХ болон БОАЖЯ-нд хүргүүлэхээр заасан байхад хүргүүлээгүй байна. Энэ нь сумын Засаг дарга нараас БНАТ-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг журмын хавсралт маягтын дагуу хүргүүлээгүйтэй холбоотой байна.
- Сумдын Засаг дарга 2022 оны БНАТ-ын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан журамд аймгийн БОАЖГ-т хүргүүлэхээр заасан байхад хүргүүлээгүй байна.
- Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн

бүрдүүлэлтийг үзэхэд аймгийн БОАЖГ БНАТ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, БОХНСАХ-ний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг мэдээллийн санд оруулсан ч зарим мэдээллийг зөрүүтэй, дутуу оруулсан байна. Тухайлбал, аймгийн 2023 оны БНАТ-ийн орлогын төлөвлөгөөний дүнг аймгийн ИТХ-ын баталсан дүнгээс илүү дүнгээр оруулсан, Хэрлэн сумаас бусад сумын төлбөрийн орлогын төлөвлөгөөний дүнг журмын хавсралт маягтын дагуу оруулаагүй, аймгийн БНАТ-ын орлогын хэсгийн зарцуулалтын тайлангийн мэдээллийг журмын хавсралт маягтын дагуу бүрэн оруулаагүй байна.

- Сумдын эрх бүхий албан тушаалтнууд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд 2022, 2023 онд сумын түвшинд хамаарах БНАТ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн 3 мэдээллийг журмын хавсралт маягтын дагуу оруулахаас огт оруулаагүй байна.
- Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангаас иргэд, олон нийт мэдээлэл авах боломжгүй байна. Энэ нь мэдээллийн сан бүрэн гүйцэд болоогүй, хөгжүүлэлтийн шатанд байгаатай холбоотой байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд хууль, журмын хэрэгжилт, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн бүрдүүлэлт муу байна.

Иймд аудитаар сумдын Засаг даргад БНАТ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, БОХНСАХ-ний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг журмын хавсралт маягтын дагуу бэлтгэж байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд оруулж байх зөвлөмжийг өгөв.

Харин Шилэн дансны цахим хуудаст 2022 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 10 сарын мэдээллийг мэдээлэхээс бүрэн мэдээлсэн байна.

В.1.2. Аймаг, сумдын Засаг дарга, БОАЖГ хууль, журмын хэрэгжилтийг хангахад үр дүнтэй хамтарч ажиллаагүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах төрийн байгууллагуудын хамтарч ажиллах уялдаа холбоо хангалтгүй байна. Тухайлбал,

- Бүх сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, татварын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал, санхүүгийн албаны дарга болон холбогдох бусад байгууллагууд нь Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд байршуулах мэдээллийг хамтарч бэлтгэхээр ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралт маягтад заасан байхад огт бэлтгээгүй,
- Аймгийн Засаг дарга, БОАЖГ, сумдын Засаг дарга нарын байгаль орчны мэдээллийн сангийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хангах ажлын уялдаа муу байна.
- Бүх сумд БНАТ-ийн орлоготой ч БНАТ-ийн орлогын хэсгээс БОХНСАХ-ний зардлыг төлөвлөх талаар аймгийн Засаг дарга, БОАЖГ болон холбогдох бусад байгууллагуудтай хамтарч ажиллахгүй байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд аймаг, сумдын Засаг дарга, БОАЖГ хууль, журмын хэрэгжилтийг хангахад үр дүнтэй хамтарч ажиллаагүй гэж харагдаж байна.

Иймд аудитаар аймгийн Засаг даргад БНАТ-ийн хууль, журмын хэрэгжилтийг хангах хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зөвлөмжийг өгөв.

В.2. Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үр дүнг үнэлээгүй байна.

В.2.1. БОАЖЯ-аас байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийгдээгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2016-2021 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийхэд Дорнод аймагт хуулийн хэрэгжилт 2021 онд 28%, 2022 онд 63%-тай гэж дүгнэсэн байна. Үүнээс үзэхэд яамнаас БНАТ-ийн орлогын хэсгээс БОХНСАХ-нд зарцуулсан зардалд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн ч Дорнод аймагт байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийгдээгүй гэж харагдаж байна.

Аймгийн хэмжээнд байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөө байхгүй ч БОАЖГ 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд түүнтэй холбогдох арга хэмжээг тусгаж хэрэгжүүлсэн байна.

Аудитаар байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж ажилласан эсэхэд Баян-Уул сумын Сум дундын ойн анги, Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын үйл ажиллагааг хамааруулж үзэхэд Баян-Уул сумын Сум дундын ойн анги нь 2021, 2022 онд хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх чиглэлээр сумын цагдаа, байгаль хамгаалагчтай хамтарсан байдлаар хяналт шалгалтыг хийсэн байна.

Харин мэргэжлийн байгууллагын зүгээс орон нутагтай хамтарч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хяналт хийгдээгүй байна.

В.2.2. Аймгийн ИТХ нь хяналт тавих эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн ИТХ нь аймгийн төсвийг батлахдаа 2021 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийг 4,346.0 сая төгрөгөөр, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 719.1 сая төгрөгөөр, 2022 оны байгалийн нөөц ашигласны төлбөр /үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр/-ийг 3,949.5 сая төгрөгөөр, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг 1,423.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Үүнээс хууль, журамд нийцэхгүй 2021 онд хэрэгжүүлэх 164.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ-г, 2022 онд хэрэгжүүлэх 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г тус тус баталсан байна.

Аудитын явцад аймгийн ИТХ-ын 2021, 2022 оны төлөвлөгөө, тайлангаас үзэхэд 2021, 2022 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих,” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Байгууллагын гудамж: 9 дугаар баг
Хэрлэн сум, Дорнод аймаг: 21000
Утас: 7058-4302, факс: 7058-4384
Цэвэрхүүрэн: audit@domed.gov.mn
Цэвэрхүүрэн: domed.gov.mn

2023.06.19 № 1/1562

Тайлбар хүргүүлэх тухай

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитаар 4.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн тул дараах тайлбарыг хүргүүлж байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар 2022 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 2.3.16-д "Ойг нөхөн сэргээх, тарьж ургуулах, мод үржүүлгийн ажилд хяналт тавих. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийн зардал"-д 20.0 сая төгрөг батлагдсан. Үүнээс ажлын хэсгийн сумдаар ажилласан бензиний зардалд 2.3 сая төгрөгийг батлагдсан төсвийн зардал хооронд шилжүүлэн хэтрүүлэн зарцуулсан байна. Үүний шалтгаан нь төсөв батлах үед түлш 2700 төгрөг байсан бол 2022 онд 3600-4100 төгрөг болж үнэ өссөн, томилолтын зардал Монгол улсын Сангийн сайдын 2022 оны 6 дугаар сарын 02-ний өдрийн 120 тоот тушаалаар 40% нэмэгдсэн зэрэг шалтгаанаас зардал хооронд хэтэрсэн байна.

Хэрлэн голыг хамгаалах менежментийн төлөвлөгөөний дагуу 2021 онд Чойбалсан хотын хог хаягдлын төвлөрсөн цэг дэх хог хаягдлыг дарж булах ажилд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах ажлын хүрээнд 2 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хөрөнгөөр хийхээр нэмэлт тодотголоор төсөвлөн оруулж хэрэгжилтийн ханган ажилласан.

НҮБ-ийн байгаль орчин, хог хаягдлын менежментийн зөвлөх Б.Дэлгэрбаярыг урьж Чойбалсан хотын одоо ашиглаж байгаа хог хаягдлын төвлөрсөн цэг болон шинээр байгуулах хог хаягдлын төвлөрсөн цэг, Булган сумын хог хаягдлын төвлөрсөн цэгтэй газар дээр нь үзэж танилцан, хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр зөвлөмжийг ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн дагуу Хэрлэн сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах одоо ашиглаж байгаа хог хаягдлын төвлөрсөн цэгийн хаалтын ажлын зураг, төсөв, Баянтүмэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт шинээр байгуулах хог хаягдлын төвлөрсөн цэгийн ерөнхий төлөвлөгөө, ландшафтийн байгууламжийн зураг төсвийн ажлын даалгаврыг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан төндөр зарлагдан мэргэжлийн байгууллагаар хийлгээд байна.

2

Аймгийн Засаг даргад ирүүлсэн 4 чиглэл бүхий зөвлөмжийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг хангаж зохион байгуулж ажиллах болохыг үүгээр мэдэгдэж байна.

ЗАСАГ ДАРГАЙН
ОРЛОГЧ Ш.ЕЛ

2123 1102

Саналд өгөх тайлбар:

Аймгийн Засаг даргын орлогчоос 2023.06.19-ний өдрийн 1/1562 тоот албан бичгээр БОХНСЗ-д тавигдсан 4.3 сая төгрөгийн төлбөрийн акттай холбоотой тайлбарыг ирүүлсэн байна. Аудитын багаар тайлбарыг хэлэлцүүлж, “шалтгаан, тайлбар зохих түвшинд байна” гэж үзэн албан шаардлага болгон өөрчлөх саналыг удирдлагын түвшинд танилцуулан тайлан, тушаалд өөрчлөлтийг тусгав.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

А.1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь Газрын төлбөрийн тухай хууль болон Төсвийн тухай хуультай уялдахгүй байна.

А.1.2. Аймгийн хэмжээнд дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг баталж, 2021-2022 онуудад тусгасан төсөл, арга хэмжээ 83-96 хувьтай хэрэгжсэн байна.

А.1.3. Аймгийн ой, ус, агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжих хугацаа 2021-2022 онд дуусаж, 2017 оноос хойш газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй явж байна.

А.2.1. БОАЖС аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан 2021, 2022 оны гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.

А.2.2. Аймгийн Засаг дарга БОАЖГ-ын дарга, сумдын Засаг даргатай байгуулсан 2021, 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох арга хэмжээг тусгаж, дүгнэсэн байна.

Б1.1. Аймгийн ИТХ нь Дорнод аймгийн хэмжээнд 2021-2023 онуудад агнах ан амьтны тоо хэмжээг тогтоож батлаагүй, БОАЖЯ-наас 2023 онд барих загасны төрөл, дээд хэмжээг хугацаа хоцроож баталсан байна.

Б.1.2. Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.

байна.

Б1.3. Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон байна.

Б1.4. БНАТ-ын төлбөрийг өмнөх жилийн дундаж хэмжээг баримтлан төлөвлөж, үндэслэлгүй ноогдуулж, төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Б.2.1. БОХНС арга хэмжээнд усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд заасан хувь хэмжээний дагуу төлөвлөж, батлахгүй байна.

Б.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд 2021 онд 4 төсөл арга хэмжээ буюу 16%, 2022 онд 5 төсөл арга хэмжээ буюу 17.8% нь төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

В.1.1. Хууль, журмын хэрэгжилт, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн бүрдүүлэлт муу байна.

В.1.2. Аймаг, сумдын Засаг дарга, БОАЖГ хууль, журмын хэрэгжилтийг хангахад үр дүнтэй хамтарч ажиллаагүй байна.

В.2.1. БОАЖЯ-аас байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийгдээгүй байна.

В.2.2. Аймгийн ИТХ нь хяналт тавих эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 6,473.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 6,473.2 сая төгрөгийн зөрчилд 16 албан шаардлага, 16 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусган Засгийн газар, БОАЖЯ-нд уламжлан шийдвэрлүүлэх 5 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. БНАТ-ийн тухай хуулийн 18.1 дэх заалт болон Газрын төлбөрийн тухай хуулийн 10.1, Төсвийн тухай хуулийн 23.8.1 дэх заалтуудыг уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах талаар Засгийн газарт уламжлах. (А.1.1 дэх асуудлын хүрээнд.)
2. Аймгийн бодлогын баримт бичгүүдэд байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх талаар БОАЖЯ-нд уламжлах. (А.1.2 дахь асуудлын хүрээнд.)
3. Баян-Уул сумын ой зохион байгуулалтын ажилд шаардагдах санхүүжилтийг улсын төсвийн эх үүсвэрээр шийдвэрлэж, ой, агнуурын менежментийн төлөвлөгөөг 2023 онд багтаан батлах, цаашид менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, дүгнэн аймгуудад мэдээлэх талаар БОАЖЯ-нд уламжлах. (А.1.3 дахь асуудлын хүрээнд.)
4. Тухайн онд барих загасны төрөл, дээд хэмжээг тогтоохдоо хэрэгжүүлэх боломжтой байдлаар баталж байх талаар БОАЖЯ-нд уламжлах. Тухайлбал 2023 онд барих загасны дээд хэмжээг 2022 оны 11-12 сард багтаан баталж, аймгийн Засаг даргад хүргүүлж байх шаардлагатай байна. (Б.1.1 дэх асуудлын хүрээнд.)
5. Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг мэдээлж байх талаар БОАЖЯ-нд уламжлах. (В.2.1 дэх асуудлын хүрээнд.)

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга М.Энхтөрд:

1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. (А.1.2, В.2.2 дахь асуудлын хүрээнд.)
2. Аймгийн ИТХ-ын тогтоолоор тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг төрөл тус бүрээр тогтоож баталдаг байх. (Б.1.1 дэх асуудлын хүрээнд.)
3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаарыг баримтлан төлөвлөж батлах. (Б.2.1 дэх асуудлын хүрээнд.)

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнд:

1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. (А.1.2 дахь асуудлын хүрээнд.)
2. Ойн ангийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах. (А.1.3 дахь асуудлын хүрээнд.)
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн суманд хамаарах орлогын хэсгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төлөвлөж,

батлуулах талаар сумын Засаг дарга нарт үүрэг чиглэл өгөх, сумын чиг үүргийг аймагт хамааруулахгүй байх. (Б.2.1 дэх асуудлын хүрээнд.)

4. БНАТ-ийн хууль, журмын хэрэгжилтийг хангах хамтын ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах. (В.1.2 дахь асуудлын хүрээнд.)

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга А.Гантулгад:

1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. (А.1.2 дахь асуудлын хүрээнд.)
2. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн программын ашиглалтыг сайжруулах замаар орлого бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлэх. (Б.1.2 дахь асуудлын хүрээнд.)
3. Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын 3.5, 3.6-д заасан төсөл арга хэмжээг төлөвлөж санхүүжүүлэх, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулахгүй байх. (Б.2.2 дахь асуудлын хүрээнд.)
4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, БОХНСАХ-ний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг журмын хавсралт маягтын дагуу нэгтгэж, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд оруулж байх. (В.1.1 дэх асуудлын хүрээнд.)

Татварын хэлтсийн дарга С.Бямбарагчаа:

1. Ан амьтан, усны төлбөрт өмнөх онуудад үндэслэлгүй ногдуулалт, тайлагналт, бичилтийн зөрүүтэй мэдээлэл үүссэнийг татварын нэгдсэн системд залруулга хийх ажлыг зохион байгуулах. (Б.1.4 дэх асуудлын хүрээнд.)

Онон-Улз голын сав газрын захиргааны дарга Б.Баяртогтоход:

1. Онон, Улз голын сав газрын усны менежментийн төлөвлөгөө боловсруулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсвөөр шийдвэрлүүлж, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах. (А.1.3 дахь асуудлын хүрээнд.)

Буйр – Мэнэнгийн талын сав газрын захиргааны дарга Ш.Хангарьдад:

1. Буйр нуурын сав газрын усны менежментийн төлөвлөгөө боловсруулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсвөөр шийдвэрлүүлж, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах. (А.1.3 дахь асуудлын хүрээнд.)

Сумдын Засаг дарга нарт:

1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаарыг баримтлан төлөвлөж батлах. (Б.2.1 дэх асуудлын хүрээнд.)
2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, БОХНСАХ-ний зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг журмын хавсралт маягтын дагуу бэлтгэж байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд оруулж байх. (В.1.1 дэх асуудлын хүрээнд.)

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 19 өдөр Дугаар А/20 Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (М.Энхтөр), аймгийн Засаг дарга (М.Бадамсүрэн), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантулга), Татварын хэлтсийн дарга (С.Бямбарачаа), Усны сав газрын дарга нар, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Я.Зориг)-т даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010044



Төргүүлэх аудиторов 2023 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн А/20 дугаар тушаалын хавсралт

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр, албан тушаал	Нийцлийн аудитын дугаар	Шийдвэрийн төрөл	Албан шаардлагын утга	Мөнгөн дүн /сая.төг/
1	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	ДОА-2023/30-9-ШТА-НА	Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	607.9
2	Татварын хэлтсийн дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	5,865.3
3	Хэрлэн сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
4	Халхил сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
5	Матад сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
6	Хөлөнбуйр сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
7	Булган сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
8	Баянтүмэн сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
9	Цагаан-Овоо сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
10	Баян-Уул сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
11	Баяндун сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
12	Дашбалбар сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
13	Чулуунхороот сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
14	Гурванзагал сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
15	Чойбалсан сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
16	Сэргэлэн сумын Засаг дарга		Албан шаардлага	Зөрчил арилгах тухай	-
	Нийт дүн				6,473.2

---oOo---

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn